



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 1/42

Батноров сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Байгууллагын 2025 оны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжид 7.146.500 (Долоон сая нэг зуун дөчин зургаан мянга таван зуун) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн зардал болох 7.146.500 (Долоон сая нэг зуун дөчин зургаан мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Багаж тоног төхөөрөмжийн зардлаас бодож олгохыг Нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА

А.БОРЧУЛУУН

